



МОНГОЛБАНК

**ХҮРТЭЭМЖТЭЙ БӨГӨӨД ТОГТВОРТОЙ ЭДИЙН ЗАСГИЙН
ӨСӨЛТИЙН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ**

Баярсайханы Золзаяа¹

¹ Монголбанкны Эдийн засгийн судалгаа, сургалтын хүрээлэнгийн эдийн засагч, эдийн засгийн ухааны доктор (Ph.D.).
Цахим шуудан: zolzaya.b@mongolbank.mn.

ХУРААНГУЙ

Энэхүү ажлын хүрээнд хүртээмжтэй бөгөөд тогтвортой эдийн засгийн өсөлтийн судалгаа, шинжилгээнд эрсдэлийн зураглал ашиглах арга зүйг боловсруулав. Судалгааны үр дүнд Монгол улсад хүртээмжтэй бөгөөд тогтвортой эдийн засгийн өсөлтийг хангахад тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлсон. Манай орны хувьд эдийн засгийн хүрээний асуудлууд дунд түвшний эрсдэлтэй бол эрүүл мэнд, боловсрол, байгаль орчны үзүүлэлтүүд эрсдэл өндөртэй нь тогтоогдсон. Иймд цаашид тэдгээрийн зорилтуудыг эргэн харж, бодлого боловсруулах шаардлагатай байна.

Түлхүүр үг: хүртээмжтэй өсөлт, тогтвортой эдийн засгийн өсөлт, хүртээмжтэй бөгөөд тогтвортой эдийн засгийн өсөлтийн эрсдэлийн үнэлгээ, тогтвортой хөгжлийн зорилт

JEL ангилал: I31, I38

1. УДИРТГАЛ

Дэлхийн эдийн засгийн өсөлт эрчимтэй байх үед буюу 20-р зууны сүүлч, 21-р зууны эхэн үед шийдэл олоогүй нийгэм эдийн засгийн гол асуудлуудын тоонд ядуурал, ажилгүйдэл, тэгш бус байдал зүй ёсоор багтдаг. Сүүлийн жилүүдэд хөгжиж буй төдийгүй хөгжингүй улс орнуудад ч эдийн засгийн өсөлт саарч, инфляц, төсвийн алдагдал, улсын өр зэрэг макро үзүүлэлтүүд сөрөг дүр зурагтай байгаа нь эдгээр асуудлуудад улам их анхаарал хандуулахад хүргэж байна.

Хэдийгээр 1990 оноос хойш дэлхийн хүн амын ядуурлын түвшин дөрөв дахин багассан ч ойролцоогоор 650 сая хүн нэн ядуу амьдарсаар байна. Хөдөлмөр эрхлэлтийн түвшин 1% нэмэгдэхэд 1980-аад онд ДНБ-ий 3%-ийн өсөлт нөлөөлж байсан бол 1990-д онд 8%-ийн өсөлт нөлөөлдөг болсон. Баян ядуугийн ялгаа мөн нэмэгдэж, 2021 оны байдлаар дэлхийн хүн амын хамгийн чинээлэг 10% баялгийн 76%-г эзэмшиж, орлогын 52%-г хүртэж байхад хүн амын бага орлоготой 50% баялгийн 2%-г эзэмшиж байна. Улмаар бодлого боловсруулагчид болон судлаачид дотоодын нийт бүтээгдэхүүн, үндэсний нийт бүтээгдэхүүн зэргээр хэмжигдэх эдийн засгийн өсөлт нийгэм, эдийн засгийн гол асуудлуудыг шийдвэрлэхэд хангалтгүй болохыг хүлээн зөвшөөрч, “хүртээмжтэй бөгөөд тогтвортой өсөлт”-ийн үзэл баримтлалд анхаарал хандуулах болсон.

Олон улсын түвшинд тогтвортой бөгөөд хүртээмжтэй өсөлтийн албан ёсны 17 зорилго, 169 зорилтыг 2015 онд “Тогтвортой хөгжлийн зорилт-2030” гэх нэршлээр НҮБ-ын Ерөнхий ассамблейн хурлаар баталсан бөгөөд тэдгээрт 2030 он гэхэд хүрэхээр 193 улс орны тэргүүд нэгдсэн байдаг. Манай орны хувьд мөн тухайн онд нэгдсэн бөгөөд 2016 онд УИХ-ын 19 дүгээр тогтоолоор “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ыг баталсан. Харин 2020-онд УИХ-ын 52 дугаар тогтоолоор “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг баталснаар өмнөх баримт бичгийг хүчингүй болгосон байна. Улмаар манай орны хувьд тогтвортой бөгөөд хүртээмжтэй эдийн засгийн өсөлт, түүний зорилго ба зорилтууд албан ёсоор “Алсын хараа-2050”-ийн хүрээнд тодорхойлогдож байна.

Энэхүү судалгааны ажлын хүрээнд бид манай орны тогтвортой бөгөөд хүртээмжтэй эдийн засгийн өсөлтийн зорилго ба зорилтууд олон улс дахь чиг хандлагатай нийцтэй байгаа эсэхийг тодруулан тэдгээрийн биелэлтийн эрсдэлийг үнэлэхээр зорив.

Судалгааны ажлын онолын хэсэгт хүртээмжтэй бөгөөд тогтвортой эдийн засгийн өсөлтийн тодорхойлолт, цар хүрээ зэргийг судалж, удаах хэсэгт судлагдсан байдлыг тоймлон, дараагаар нь судалгааны арга зүй болон үр дүнг тайлбарласан. Эцэст нь дүгнэлт, саналыг боловсруулав.

2. ОНОЛЫН ХЭСЭГ

Хүртээмжтэй бөгөөд тогтвортой өсөлтийн үзэл баримтлалыг анх нобелийн шагналт М.Спенс тэргүүтэй судлаачид боловсруулан 2008 онд “Өсөлтийн тайлан. Тогтвортой өсөлт, хүртээмжтэй хөгжлийн стратеги” /“The growth report. Strategies for Sustained Growth and Inclusive Development”/-д нийтэлсэн. Өдгөө эдийн засагчид хүртээмжтэй бөгөөд тогтвортой өсөлтийг олон янзаар тодорхойлдог боловч түүнийг өргөн хүрээний асуудлуудыг хамарна гэдэг дээр санал нэгддэг. Энэхүү ажлын хүрээнд бид В.Серра [1] нарын тодорхойлсны дагуу хүртээмжтэй бөгөөд тогтвортой өсөлтийг (1) эдийн засгийн өсөлт, (2) өсөлтийн хүртээмж болон (3) өсөлтийн тогтвортой байдал гэх үндсэн гурван асуудлын хүрээнд судлав. Эдгээрийн хүртээмжтэй бөгөөд тогтвортой өсөлтөд хэрхэн нөлөөлөхийг дор тоймлов.

(1) *Эдийн засгийн өсөлт* нь үнэ цэнэ бүхий бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэл болон үйлчилгээ нэмэгдэхэд нөлөөлж, улмаар амьжиргааны түвшин дээшлэхэд хүргэнэ. Эдийн засгийн өсөлт мөн ажлын байр нэмэгдэхэд эергээр нөлөөлж, улмаар ядуурлын түвшин буурахад нөлөөлнө. Үүний зэрэгцээ эдийн засаг өсөхийн хэрээр татварын орлого нэмэгдэх бөгөөд төрийн үйлчилгээний санхүүжилт нэмэгдэнэ.

(2) Эдийн засгийн өсөлт *хүртээмжтэй* байх нь амьжиргааны түвшний ахиц нийгмийн бүх бүлгүүдэд явагдахад түлхэц болдог байна. Хүртээмжтэй өсөлтийг дараах үндсэн дөрвөн асуудлын хүрээнд авч үздэг.

(a) *Ашигийн хуваарилалт* буюу нас, хүйс, арьс өнгө, үндэс угсаа, бүс нутаг, шашин шүтлэг зэрэг хувь хүний онцлогоос үл хамааран нийгмийн бүх бүлгүүдийн орлогыг нэмэгдүүлж, ядуурлыг бууруулах. Ингэхдээ эдийн засгийн нөөц бололцоог хэмжихдээ орлогоос илүүтэй тэгш бус хуваарилагддаг, эдийн засаг, нийгэм, улс төрийн хувьд нөлөө бүхий хүчин зүйл болох баялаг болон нийгмийн сайн сайхан байдлын бусад хэмжүүрүүдийг харгалзах нь зүйтэй байна.

(б) Эрүүл мэнд, боловсрол зэрэг үндсэн үйлчилгээнүүдэд хамрагдах боломж буюу хүн бүрд авьяас чадвараа хөгжүүлж, үр бүтээлтэй амьдрах боломж олгох.

(в) Эдийн засгийн амьдралд идэвхтэй оролцох боломжийг хэрэгцээт ажлын байраар ханган бүрдүүлэх.

(г) Нийгэм, улс төрийн амьдрал дахь эрх мэдэл, боломжийн хүрээг тэлэх буюу эдийн засгийн сайн сайхан байдлаас гадна засаглалын хүчирхэг тогтолцоог бэхжүүлж, төрийн секторын хариуцлагыг нэмэгдүүлж, иргэдэд өөрсдийн санал бодлоо илэрхийлэх боломжийг олгох.

(3) Эдийн засгийн өсөлт хүртээмжтэй байхад түүний *тогтвортой* эсэх мөн чухал ач холбогдолтой. Өнөөгийн хэрэглээ, нийгмийн халамж нь одоогийн болон хойч үеүдийн ирээдүйг тогтвортой байлгахад нөлөөлдөг. Өөрөөр хэлбэл, өнөөгийн эдийн засгийн өсөлтийг хангахдаа тогтворгүй, өрийг ихээр нэмэгдүүлэх эсвэл бусад санхүүгийн хямралд хүргэж болзошгүй бодлогууд хэрэгжүүлэх нь эрсдэлтэй. Энэ хүрээнд мөн хүрээлэн буй орчны тогтвортой байдлыг ханган, хойч үеүддээ байгалийн баялгийн үр шимийг хүртэх боломж олгох нь чухал юм.

Эдгээр үндсэн асуудлуудын хүрээнд олон улсын түвшинд тогтвортой бөгөөд хүртээмжтэй өсөлтийг дэмжихээр албан ёсны 17 зорилго, 169 зорилтыг 2015 онд “Тогтвортой хөгжлийн зорилт-2030” гэх нэршлээр НҮБ-ын Ерөнхий ассамблейн хурлаар баталсан. Тэдгээрт 2030 он гэхэд хүрэхээр манай улсаас гадна 192 улс орны тэргүүд нэгдсэн байдаг. 2017 оны 3 сард НҮБ-ын Статистикийн комиссын чуулганаар Тогтвортой хөгжлийн зорилтын хэрэгжилтийг дүгнэх 244 шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон [2].

Хүртээмжтэй бөгөөд тогтвортой эдийн засгийн өсөлт нь дан ганц нийгэм, эдийн засгийн төдийгүй байгаль орчны асуудлуудтай уялдан өргөн цар хүрээг хамардаг байна. Иймд түүний судалгаа, шинжилгээ, хөгжлийн бодлого боловсруулахад үзүүлэлтүүдийг цогцоор нь харж, доголдож байгаа асуудалд хандуулах анхаарлыг нэмэгдүүлэх нь ач холбогдолтой.

3. СУДЛАГДСАН БАЙДЛЫН ТОЙМ

Дэлхийн эдийн засгийн өсөлт эрчимтэй байх үед буюу 20-р зууны сүүлч, 21-р зууны эхэн үед шийдэл олоогүй нийгэм эдийн засгийн гол асуудлуудын тоонд ядуурал, ажилгүйдэл, тэгш бус байдал зүй ёсоор багтдаг. Сүүлийн жилүүдэд хөгжиж буй төдийгүй хөгжингүй улс орнуудад ч эдийн засгийн өсөлт саарч, инфляц, төсвийн алдагдал, улсын өр зэрэг макро үзүүлэлтүүд сөрөг дүр зурагтай байгаа нь эдгээр асуудлуудад улам их анхаарал хандуулахад хүргэж байна.

Хэдийгээр 1990 оноос хойш дэлхийн хүн амын ядуурлын түвшин 78% буурсан ч арван хүн тутмын нэг нь ядуу амьдарсаар байна [3]. Хөдөлмөр эрхлэлтийн түвшин 1% нэмэгдэхэд 1980-аад онд ДНБ-ий 3%-ийн өсөлт нөлөөлж байсан бол 1990-д онд 8%-ийн өсөлт нөлөөлдөг болсон [4]. Баян ядуугийн ялгаа мөн нэмэгдэж, 2021 оны байдлаар дэлхийн хүн амын хамгийн чинээлэг 10% баялгийн 76%-г эзэмшиж, орлогын 52%-г хүртэж байхад хүн амын бага орлоготой 50% баялгийн 2%-г эзэмшиж байна [5]. Улмаар бодлого боловсруулагчид болон судлаачид дотоодын нийт бүтээгдэхүүн, үндэсний нийт бүтээгдэхүүн зэргээр хэмжигдэх эдийн засгийн өсөлт нийгэм, эдийн засгийн гол асуудлуудыг шийдвэрлэхэд хангалтгүй болохыг хүлээн зөвшөөрч, “хүртээмжтэй бөгөөд тогтвортой өсөлт”-ийн үзэл баримтлалд анхаарал хандуулж байна.

Глобал түвшинд одоогоор хүртээмжтэй бөгөөд тогтвортой эдийн засгийн өсөлтийн ач холбогдлыг тодруулан түүнийг олон талаас нь тодорхойлдог. Үүний зэрэгцээ хүртээмжтэй бөгөөд тогтвортой эдийн засгийн өсөлтийн эцсийн зорилго, түүнд хүрэх зорилтууд болон тэдгээрийн биелэлтийг хэмжих үзүүлэлтүүдийг албан ёсоор тодорхойлсон байгааг бид өмнөх хэсэгт дурдсан.

Манай орны хувьд хүртээмжтэй бөгөөд тогтвортой эдийн засгийн өсөлтийн талаарх судалгааны ажлууд цөөн байгаа ч сүүлийн жилүүдэд нэмэгдэж байна. 2012 онд Д.Даваасүх [6] судалгаандаа хүртээмжтэй эдийн засгийн өсөлтийн индексийг Монгол Улсын хувьд тооцож, тус индексийн өөрчлөлтөд эдийн засгийн өсөлт, нийгмийн халамжаас тэгш хүртэх байдал харьцангуй их нөлөөтэй бол дэд бүтэц, сайн засаглал, нийгмийн хамгаалал зэрэг нь өсөлтөд бага нөлөөтэй байгааг тогтоожээ.

Сүүлийн жилүүдэд хийгдсэн ажлуудаас дурдвал судлаач Ц.Амартүвшин, С.Болормаа [7] нар Монгол улс дахь эдийн засгийн өсөлтийн хүртээмжтэй байдлыг

холбогдох үзүүлэлтүүдийг харьцуулан тодорхойлсон ба орлогын тэгш бус байдал буурахгүй, нэг өрхөд ноогдох ажилтай хүний дундаж тоо хүн амын ядуу хэсэгт илүү өндөр байгаа хэдий ч цалингийн орлогын дундаж хэмжээ хүн амын чинээлэг хэсэгтэй харьцуулахад доогуур байгааг онцолжээ. Улмаар Монгол Улсын хувьд эдийн засгийн өсөлт ядуурлыг бууруулсан боловч хүн амын амьжиргааг сайжруулахад хангалттай нөлөө үзүүлж чадахгүй, хүртээмж муутай байна гэж дүгнэжээ.

Азийн хөгжлийн банкнаас 2017-2020 оны манай орны хүртээмжтэй бөгөөд тогтвортой өсөлтийн үнэлгээг асуудал бүрийн шинжилгээнд тулгуурлан хийсэн байна [8]. Үнэлгээний үр дүнгээс харахад эдийн засгийн засаглал сул, нийгэм ба хүний хөгжлийн жигд бус ололт, эдийн засгийн бааз суурийн хязгаарлагдмал байдал, байгаль орчны доройтол, уур амьсгалын өөрчлөлт зэрэг нь манай орны хүртээмжтэй бөгөөд тогтвортой өсөлтөд саад болж буй гол хүчин зүйлс болдог байна.

Монголбанкны эдийн засагчид [9] мөн Монгол Улсын хувьд хүртээмжтэй эдийн засгийн зарим асуудлуудыг үзүүлэлт тус бүрийн түвшинд үндэслэн ерөнхийдөө сул байна гэх дүгнэлтэд хүрсэн байна. Үүнээс гадна манай орны хувьд хүртээмжтэй өсөлтийг хэмжих шаардлагатай статистик тоо мэдээллийн хүрээг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах нь өргөн хүрээтэй дүн шинжилгээ хийхэд шаардлагатайг онцолжээ.

Дэлхийн банкны эдийн засагчид [10] Монгол Улсын хүртээмжтэй өсөлтөд тулгарч буй гол хоёр эрсдэлээр худалдан авах чадварт сөргөөр нөлөөлж буй үнийн өсөлт, төсвийн дэмжлэгийн үр ашиггүй хуваарилалт зэргийг нэрлэсэн байна. Улмаар эдгээр хүчин зүйлс нь ядуу, эмзэг бүлгийн өрхүүдийг хамгаалах шаардлагыг улам бүр нэмэгдүүлж, Монгол Улсын дундаас дээш орлоготой орон болох зорилгоос хазайлгаж байна хэмээжээ.

Монгол Улсын хүртээмжтэй бөгөөд тогтвортой эдийн засгийн өсөлтийн талаар хийгдсэн судалгаануудын шинжилгээний арга зүй болон үр дүнгээс үзэхэд доголдолтой байгаа асуудлуудыг тодруулсан боловч бүх үзүүлэлтүүдийг харьцуулсан ажил хараахан хийгдээгүй байна. Иймд бид тус асуудалд анхаарал хандуулан хүртээмжтэй бөгөөд тогтвортой хөгжлийн зорилтуудын биелэлтийг үнэлнэ.

4. АРГА ЗҮЙ

Энэхүү судалгааны ажлын зорилгын хүрээнд бид эдийн засгийн хүртээмжтэй байдлыг илэрхийлэх 4 асуудал болон түүний тогтвортой байдлыг илэрхийлэх 244 үзүүлэлтийг судалсан. Улмаар хүртээмжтэй байдлын 4 асуудал тогтвортой байдлын үзүүлэлтүүдэд Хүснэгт 1-ийн дагуу тусгагдсан гэж үзэв:

<i>Хүснэгт 1</i>	
Хүртээмжтэй болон тогтвортой байдлын үзүүлэлтүүдийн хамаарал	
Хүртээмжтэй байдлын үзүүлэлт	Тогтвортой байдлын үзүүлэлт
Ашгийн хуваарилалт	Орлогын тэгш бус байдлын үзүүлэлт, ядуурлын түвшин
Эрүүл мэнд, боловсролын үйлчилгээнд хамрагдах боломж	Ерөнхий боловсролын сургуулийн анги дүүргэлт, 1000 амьд төрөлтөд нялхсын эндэгдлийн түвшин, 100000 амьд төрөлтөд эхийн эндэгдлийн түвшин, дундаж наслалт
Эдийн засгийн амьдралд идэвхтэй оролцох боломж	Эдийн засгийн идэвхтэй хүн амын нийгмийн даатгалд хамрагдсан байдал, ядуурлын түвшин
Засаглалын хүчирхэг тогтолцоо	Өрсөлдөх чадварын үзүүлэлт

Эх сурвалж: судлаачийн нэгтгэл

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод хүртээмжтэй бөгөөд тогтвортой хөгжлийн асуудлууд хэрхэн тусгагдсан байгааг дор дурдсан холбогдох баримт бичгүүд, тэдгээрийн хүрээнд хүрэхээр зорьсон зорилго, зорилтууд болон үр дүнг илэрхийлэх үзүүлэлтүүдийг харьцуулан судалсан.

- Глобал тогтвортой хөгжлийн 17 зорилго, 169 зорилт, 244 үзүүлэлт,
- Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030-д тусгагдсан байсан 10 зорилго 20 үзүүлэлт,
- “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд хүрэхээр зорьж буй 9 зорилго, 47 зорилт ба тэдгээрийг хэмжих 73 үзүүлэлт.

“Алсын хараа-2050”-д тусгагдсан хүртээмжтэй бөгөөд тогтвортой эдийн засгийн өсөлтийн үзүүлэлтүүдийн биелэлтийн түвшнийг үнэлэхдээ 2030 онд хүрэхээр зорьсон түвшнийг 100%, анх тогтвортой хөгжлийн зорилтуудыг (ТХЗ) тодорхойлсон үе буюу 2014 оны түвшнийг 0% гэж тооцон мини-макс аргачлалын дагуу *томьёо 1*-ийг ашиглан нормалчилсан.

$$x_{i \text{ norm}} = \frac{x_i - x_{\min}}{x_{\max} - x_{\min}}, \quad (1)$$

энд $x_{i \text{ norm}}$ – үзүүлэлтийн нормалчилсан тоон утга, x_i – үзүүлэлтийн тоон утга, x_{\min} – үзүүлэлтийн нийт хугацаан дахь хамгийн бага утга, x_{\max} – үзүүлэлтийн нийт хугацаан дахь хамгийн их утга.

Үүнээс гадна ядуурал, орлогын тэгш бус байдал, эх болон нялхсын эндэгдэл, ерөнхий боловсролын байгууллагын анги дүүргэлт, цөлжилт зэрэг нь бага байхдаа эерэг дүр зураг илэрхийлдэг. Иймд, эдгээр үзүүлэлтүүдийн нормалчилсан тоон утгыг *томьёо 2*-ын дагуу тооцоолж, их байхдаа эерэг байхаар засварласан.

$$y_i = 1 - x_{i \text{ norm}} \quad (2)$$


энд y_i – үзүүлэлтийн их байхдаа эерэг байхаар засварласан тоон утга.

Мөн эдийн засгийн өсөлтийн үзүүлэлтийн хувьд зорилтот түвшнийг 100% гэж тооцон түүнийг давж байгаа суурь буюу 2014 болон 2018 оны түвшнийг зорилтод хүрсэн буюу 100% гэж тооцов.


Улмаар дээр дурдсанчлан хүртээмжтэй бөгөөд тогтвортой эдийн засгийн өсөлтийн үзүүлэлтүүдийг цогцоор нь авч үзэн харьцуулж, доголдож байгаа асуудлуудыг тодорхойлохдоо heatmap буюу эрсдэлийн зураглал ашиглав. Эрсдэлийн зураглалд тоон утга өндөр байх тусам ногооноор илэрхийлэгдэж, зорилтот түвшин рүү дөхөж байгааг харуулна. Харин бага байх тусам улаанаар илэрхийлэгдэж, зорилтот түвшнээс хазайх эрсдэл их байгааг харуулна. Үүнээс гадна цаг хугацааны туршид, тухайлбал 2016-2022 онд хүртээмжтэй бөгөөд тогтвортой өсөлтийн шалгуур үзүүлэлтүүд хэрхэн өөрчлөгдсөнийг эрсдэлийн зураглалд тусгасан. Тооцооллын үр дүнг судалгааны ажлын дараагийн хэсэгт оруулав.

5. ҮР ДҮН

Судалгааны үр дүнгээс үзэхэд глобал тогтвортой хөгжлийн зорилтын 244 үзүүлэлтэд Монгол Улсад хамааралтай 233 үзүүлэлт байгаагаас тал орчим буюу 49.4%-ийг бүрдүүлэх 115 үзүүлэлтийн тоо мэдээ манай улсад гарах боломжгүй байна [11] (Зураг 1). Бусад ТХЗ-ын 118 үзүүлэлтийг зорилтуудаар ангилан дор хүснэгтлэв (Хүснэгт 2).



Эх сурвалж: судлаачийн тооцоолол



Эх сурвалж: судлаачийн тооцоолол

“Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” (ТХҮБ)-д 20 үзүүлэлтийг тусгасан байгаа боловч тэдгээр нь Глобал ТХЗ-аас ялгаатай байна. Тухайлбал, ТХҮБ-ын 20 үзүүлэлтээс 9 нь Глобал ТХЗ-ын үзүүлэлтүүдтэй давхцаж байгаа бол үлдсэн 11 нь харьцангуй шинэлэг байна. Давхцаж байгаа үзүүлэлтүүдээс 6 нь эдгээр хоёр баримт бичгийн хувьд ижил байгаа бол 3 өөр үзүүлэлтүүдийн хувьд зорилтууд нь төсөөтэй байна (Зураг 2). Үүний зэрэгцээ 8 Глобал ТХЗ-ын үзүүлэлтүүдийн хувьд хэдийгээр манай улсад хамааралтай боловч ТХҮБ-д тусгагдаагүй байна.

Хүснэгт 2

Глобал ТХЗ ба тэдгээрийн үзүүлэлтүүд

д/д	Глобал ТХЗ	Нийт үзүүлэлтийн тоо	Монгол Улсад хамааралтай үзүүлэлтүүдийн тоо	Тоо мэдээ гарах боломжтой үзүүлэлтүүдийн тоо	ТХЗ-2030-д тусгагдсан эсэх	Алсын хараа-2050-д тусгагдсан эсэх	Хүртээмжтэй эдийн засгийн асуудалд тусгагдсан эсэх
1	Эрүүл мэндийг дэмжих	27	25	16	V	V	V
2	Ядуурлыг устгах	14	14	7	V	V	V
3	Өлсгөлөнг зогсоох	13	13	7	-	-	V
4	Чанартай боловсролыг дэмжих	11	11	8	C	C	V
5	Жендерийн эрх, тэгш байдлыг хангах	14	13	8	V	V	V
6	Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах	11	11	6	-	-	V

7	Сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх	6	6	4	V	V	V
8	Эдийн засгийн өсөлт, баталгаат ажлын байрыг бий болгох	17	17	13	V	V	V
9	Инновац болон дэд бүтцийг нэмэгдүүлэх	12	12	6	-	-	-
10	Тэгш бус байдлыг бууруулах	11	11	5	V	V	V
11	Ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих	15	15	6	-	-	V
12	Хариуцлагатай хэрэглээг дэмжих	13	13	2	-	-	-
13	Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг бууруулах	8	8	3	C	C	-
14	Далай, тэнгисийн нөөцийг хамгаалах	10	2	0	-	-	-
15	Хуурай газрын эко системийг хамгаалах	14	14	5	C	C	-
16	Энх тайван, шударга ёсыг цогцлоох	23	23	12	-	-	V
17	Хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх	25	25	10	-	-	-
	Нийт үзүүлэлтийн тоо	244	233	118	9	9	11
*V – зорилт ба үзүүлэлт давхацсан, C – зорилт давхцах ч үзүүлэлт өөрчлөгдсөн.							

Эх сурвалж: судлаачийн эмхэтгэл

Хэдийгээр Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилтууд 2020 оноос эхлэн “ТХҮБ-2030” бус “Алсын хараа-2050”-аар тодорхойлогдож байгаа ч эдгээр баримт бичгүүдийн хувьд ихэнх үзүүлэлтүүд ижил, харин ялгаатай байгаа 3 үзүүлэлтүүдийн хувьд зорилтууд нь нэг байна. Тэдгээрийг Хүснэгт-3-т оруулав.

Хүснэгт 3

Алсын хараа-2050 ба ТХҮБ-2030

№	Алсын хараа-2050 үзүүлэлтүүд	№	ТХҮБ-2030 үзүүлэлтүүд
Ижил үзүүлэлтүүд			
32	Эдийн засгийн жилийн дундаж өсөлт	1	Эдийн засгийн жилийн дундаж өсөлт
4	Хүний хөгжлийн үзүүлэлт	3	Хүний хөгжлийн үзүүлэлт
11	Хүн амын дундаж наслалт	4	Дундаж наслалт
22	Ядуурлын түвшин	5	Ядуурлын түвшин
23	Өрсөлдөх чадварын үзүүлэлт	6	Өрсөлдөх чадварын үзүүлэлт
24	Бизнес эрхлэлтийн үзүүлэлт	7	Бизнес эрхлэлтийн үзүүлэлт
50	Байгаль орчны гүйцэтгэлийн үзүүлэлт EPI	8	Байгаль орчны багц үзүүлэлт
26	Эдийн засгийн идэвхтэй хүн амын нийгмийн даатгалд хамрагдсан хувь	9	Эдийн засгийн идэвхтэй хүн амын нийгмийн даатгалд хамрагдалт
13	1 000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдлийн түвшин	11	1 000 амьд төрөлтөд нялхсын эндэгдлийн түвшин
14	100 000 амьд төрөлтөд эхийн эндэгдлийн түвшин	12	100 000 амьд төрөлтөд эхийн эндэгдлийн түвшин
51	Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн эзлэх хувь	16	Тусгай хамгаалалтад авсан газар нутгийн хэмжээ
42	Хүлээн авах гадаад жуулчдын тоо	17	Гадаадын жуулчдын тоо
67	Цахилгаан эрчим хүчээр хангагдсан хүн амын эзлэх хувь	18	Цахилгаан эрчим хүчний найдвартай эх үүсвэрээр хангагдсан өрх
40	Гол нэр, төрлийн шатахууны хэрэгцээг Евро 5 стандартад нийцүүлэн дотоодоос хангах хувь	20	Гол нэр төрлийн шатахууны хэрэгцээг дотоодын эх үүсвэрээс хангах хувь

Ялгаатай үзүүлэлтүүд			
34	Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ	2	Нэг хүнд ногдох үндэсний нийт орлого
36	Боловсруулах аж үйлдвэрийн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	19	Нийт экспортод боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хэмжээ
25	Хэрэглээний тэгш бус байдлын үзүүлэлт	10	Орлогын тэгш бус байдлын үзүүлэлт

Эх сурвалж: судлаачийн эмхэтгэл

Улмаар манай улсын хүртээмжтэй бөгөөд тогтвортой эдийн засгийн өсөлтийн үзүүлэлтүүдийг нэгтгэн эрсдэлийн зураглалыг дараах байдлаар гаргасан (Зураг 3). Зураг 3-т үзүүлэлтийн биелэлтийн түвшин зорилтот түвшинтэй ойр байх тусам ногоон, холдох тусам улаан, үзүүлэлтийн тоо мэдээ хангалтгүй бол цагаан өнгөөр илэрхийлэгдэнэ.

Зураг 3

Хүртээмжтэй бөгөөд тогтвортой эдийн засгийн өсөлтийн эрсдэлийн зураглал

д/д	Үзүүлэлт	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2030
1	Эдийн засгийн жилийн дундаж өсөлт	Green	Yellow	Orange	Yellow	Green	Green	Red	Orange	Green
2	Нэг хүнд ногдох үндэсний нийт орлого	Yellow	Yellow	Orange	Red	Orange	Yellow	Yellow	Yellow	Green
3	Хүний хөгжлийн үзүүлэлт	Red	Orange	Orange	Orange	Yellow	Yellow	Yellow	Yellow	Green
4	Дундаж наслалт	Yellow	Orange	Red	Orange	Yellow	Yellow	Yellow	Yellow	Green
5	Ядуурлын түвшин	Green	Yellow	Red	Yellow	Orange	Yellow	Yellow	Yellow	Green
6	Өрсөлдөх чадварын үзүүлэлт	Red	Red	Red	Yellow	Yellow	Yellow	Yellow	Yellow	Green
7	Бизнес эрхлэлтийн үзүүлэлт	Yellow	Red	Green	Yellow	Green	Yellow	Orange	Yellow	Green
8	Байгаль орчны багц үзүүлэлт	Yellow	Yellow	Yellow	Yellow	Yellow	Green	Orange	Red	Green
9	Эдийн засгийн идэвхтэй хүн амын нийгмийн даатгалд хамрагдсан байдал	Yellow	Orange	Orange	Orange	Red	Yellow	Green	Green	Green
10	Орлогын тэгш бус байдлын үзүүлэлт	Red	Yellow	Green	Yellow	Orange	Yellow	Yellow	Yellow	Green
11	1000 амьд төрөлтөд нялхсын эндэгдлийн түвшин	Orange	Orange	Red	Yellow	Yellow	Yellow	Green	Green	Green
12	100000 амьд төрөлтөд эхийн эндэгдлийн түвшин	Yellow	Yellow	Orange	Yellow	Yellow	Green	Yellow	Red	Green
13	Ерөнхий боловсролын сургуулийн анги дүүргэлт	Yellow	Yellow	Green	Yellow	Orange	Red	Orange	Yellow	Green
14	Эрүүл газар нутгийн хэмжээ*	Red	Red	Red	Red	Red	Red	Red	Red	Green
15	Цөлжилтөд өртсөн газар нутгийн эзлэх хэмжээ	Yellow	Yellow	Yellow	Yellow	Yellow	Yellow	Yellow	Yellow	Green
16	Тусгай хамгаалалтад авсан газар нутгийн хэмжээ	Red	Red	Red	Red	Red	Green	Green	Green	Green
17	Монгол Улсад аялах гадаад жуулчдын тоо	Yellow	Yellow	Yellow	Yellow	Yellow	Yellow	Yellow	Red	Green
18	Цахилгаан эрчим хүчний эх үүсвэрээр хангагдсан өрх	Red	Yellow	Yellow	Yellow	Yellow	Yellow	Green	Green	Green
19	ДНБ дэх боловсруулах аж үйлдвэрийн оролцоо	Green	Yellow	Red	Orange	Yellow	Yellow	Yellow	Yellow	Green
20	Гол нэр төрлийн шатахууны хэрэгцээг дотоодын эх үүсвэрээс хангах хувь	Red	Red	Red	Red	Red	Red	Red	Red	Green

*Эрүүл газар нутгийн хэмжээ гэдэг нь ТХЗ-д тусгагдсаны дагуу дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагын хорио, цээрийн шаардлагад нийцсэн газар нутгийн эзлэх хэмжээ болно [11].

Эх сурвалж: судлаачийн тооцоолол

Эрсдэлийн зураглалд тулгуурлан манай орны хүртээмжтэй бөгөөд тогтвортой эдийн засгийн өсөлтийн үзүүлэлтүүдийг эрсдэлийн түвшнээр 3 ангилсан (Хүснэгт 4).

Хүснэгт 4

Хүртээмжтэй бөгөөд тогтвортой эдийн засгийн өсөлтийн үзүүлэлтүүдийн ангилал

Эрсдэлийн түвшин		
Бага	Дунд	Өндөр
9. Эдийн засгийн идэвхтэй хүн амын нийгмийн даатгалд хамрагдсан байдал 11. 1000 амьд төрөлтөд нялхсын эндэгдэл 16. Тусгай хамгаалалтад авсан газрын хэмжээ 18. Цахилгаан эрчим хүчний эх үүсвэрээр хангагдсан өрх	2. Нэг хүнд ногдох үндэсний нийт орлого 3. Хүний хөгжлийн үзүүлэлт 4. Дундаж наслалт 5. Ядуурлын түвшин 6. Өрсөлдөх чадварын үзүүлэлт 7. Бизнес эрхлэлтийн үзүүлэлт 10. Орлогын тэгш бус байдлын үзүүлэлт 19. ДНБ дэх боловсруулах аж үйлдвэрийн оролцоо	1. Эдийн засгийн жилийн дундаж өсөлт 8. Байгаль орчны багц үзүүлэлт 12. 100000 амьд төрөлтөд эхийн эндэгдлийн түвшин 13. Ерөнхий боловсролын сургуулийн анги дүүргэлт 14. Эрүүл газар нутгийн хэмжээ 15. Цөлжилтөд өртсөн газар нутгийн эзлэх хэмжээ 17. Монголд аялах гадаад жуулчдын тоо 20. Гол нэр төрлийн шатахууны хэрэгцээг дотоодын эх үүсвэрээс хангах хувь

Эх сурвалж: судлаачийн эмхэтгэл

Хүртээмжтэй бөгөөд тогтвортой эдийн засгийн өсөлтийн бага эрсдэлтэй үзүүлэлтүүдийн хувьд 2019 оноос хойш тогтмол эерэг өөрчлөлттэй төдийгүй зорилтот түвшинд ойртсон байна. Гэвч нийт үзүүлэлтүүдийн 20% нь бага эрсдэлтэй байгаа нь хангалтгүй.

Эрсдэлийн түвшин өндөртэй үзүүлэлтүүдэд хүртээмжтэй бөгөөд тогтвортой эдийн засгийн өсөлтийн үндсэн асуудал болох “эдийн засгийн өсөлт” багтаж байгаа нь анхаарал татахуйц байна. Гэвч тус үзүүлэлтийн судалгаанд хамрагдах хугацааны өөрчлөлтийг харахад эрсдэлийн түвшин 2018 онд бага байсан бол 2019, 2020 онуудад огцом нэмэгдсэн байгаа нь цар тахлын тархалт өндөр байсан цаг хугацаатай давхцаж байна. Энэхүү цаг хугацаанд тогтмол бага эрсдэлтэй байсан жуулчдын тоо мөн багассан байна.

Дээрх ангилалд анхаарал татаж буй бас нэг үзүүлэлт нь шатахууны үйлдвэрлэл байна. Гол нэр төрлийн шатахууны хэрэгцээг 100% дотоодоос хангахаар 2016 онд ТХЗ-д, удаагаар нь 2020 онд Алсын хараа-2050-д тусгасан. Гэсэн хэдий ч өнөөг хүртэл үйлдвэрлэл эхлээгүй байгаа нь манай орны хувьд хүртээмжтэй агаад тогтвортой эдийн засгийн өсөлтийн зорилтын биелэлтэд сөргөөр нөлөөлж байна. Иймд шатахууны үйлдвэрлэлийн асуудлыг эрчимжүүлэх шаардлагатай.

Өндөр эрсдэлтэй бусад үзүүлэлтүүд нь байгаль орчин, эрүүл мэнд, боловсролын хүрээний асуудлууд байна. Цөлжилтөд өртсөн газар нутгийн эзлэх хэмжээ хэдийгээр 2016 оноос хойш нийтлэгдээгүй ч тус асуудал манай орны хувьд хурцадмал мөн өндөр эрсдэлтэй байсан зэргийг харгалзан тус ангилалд багтаасан болно. Хүртээмжтэй бөгөөд тогтвортой эдийн засгийн өсөлтийн үзүүлэлтүүдийн 80% нь дунд болон өндөр эрсдэлтэй байна. Өөрөөр хэлбэл, хүртээмжтэй бөгөөд тогтвортой эдийн засгийн өсөлтийн зорилтын биелэлт өндөр эрсдэлтэй байна.

Эрсдэлийн түвшин дунд гэж үнэлэгдсэн үзүүлэлтүүд гол төлөв эдийн засгийн хүрээг хамарч байна. Тухайлбал, тус ангилалд нэг хүнд ногдох үндэсний нийт орлого, ДНБ дэх боловсруулах аж үйлдвэрийн оролцоо, хүний хөгжил, дундаж наслалт, ядуурал, өрсөлдөх чадвар, орлогын тэгш бус байдал, бизнес эрхлэлтийн үзүүлэлт зэрэг багтаж байна. Эдийн засгийн болон нийгмийн гол асуудлууд шууд хамааралтай байдгийг харгалзан дурдсан үзүүлэлтүүдийг сайжруулах шаардлагатай.

6. ДҮГНЭЛТ, САНАЛ

Энэхүү судалгааны ажлаар бид манай орны хүртээмжтэй бөгөөд тогтвортой эдийн засгийн өсөлтийн зорилго ба зорилтууд олон улс дахь чиг хандлагатай нийцтэй байгааг тодрууллаа. Гэсэн хэдий ч тоо мэдээний хязгаарлагдмал байдал судалгаа, шинжилгээ хийхэд хангалтгүй байгаа нь түүнд тулгуурлан хүртээмжтэй бөгөөд тогтвортой эдийн засгийн өсөлтийг дэмжих бодлого боловсруулахад сөргөөр нөлөөлж байна. Иймд тогтвортой бөгөөд хүртээмжтэй эдийн засгийн өсөлтийн талаарх тоо мэдээг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Хүртээмжтэй бөгөөд тогтвортой эдийн засгийн өсөлт нь өргөн хүрээний асуудлуудыг хамардаг ба түүний судалгаа шинжилгээнд тэдгээрийг цогцоор нь авч үзэх нь чухал ач холбогдолтой. Энэ хүрээнд хүртээмжтэй бөгөөд тогтвортой эдийн засгийн өсөлтийн үзүүлэлтүүдийг цогцоор нь судалж, доголдож байгаа асуудлуудыг тодорхойлох эрсдэлийн зураглалын арга зүйг боловсруулав. Эрсдэлийн зураглалыг ТХЗ-ын үзүүлэлтүүдийг үнэлэхээс гадна тэдгээрийг эрсдэлийн түвшнээр ангилахад ашиглах боломжтой.

Эрсдэлийн зураглалын дагуу Монгол Улсын хүртээмжтэй бөгөөд тогтвортой өсөлтийн зорилтуудын биелэлтийг харьцуулан тэдгээрт учирч буй эрсдэлийг үнэлсэн.

Улмаар манай орны хүртээмжтэй бөгөөд тогтвортой эдийн засгийн өсөлтийн зорилгын биелэлт өндөр эрсдэлтэй байгааг тогтоож, түүнд нөлөөлж буй үзүүлэлтүүдийн учир шалтгаан болон цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодруулсан.

НОМ ЗҮЙ

- [1] V. Cerra, *An Inclusive Growth Framework In: How to Achieve Inclusive Growth*, Oxford University Press, 2022.
- [2] “Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилт,” 2022. [Холбоос]: <http://sdg.gov.mn/>
- [3] M. Roser, “Extreme poverty: how far have we come, how far do we still have to go?,” November 2021. [Холбоос]: <https://ourworldindata.org/extreme-poverty-in-brief>
- [4] Jesus Felipe, Rana Hasan, “The Challenge of Job Creation in Asia,” ADB, Manila, 2006.
- [5] J. Myers, “These charts show the growing income inequality between the world's richest and poorest,” 10 December 2021. [Холбоос]: <https://www.weforum.org/agenda/2021/12/global-income-inequality-gap-report-rich-poor/>
- [6] Д.Даваасүх, “Хүртээмжтэй өсөлт,” *Судалгааны ажил "Товхимол 8"*, б. 8, 2012.
- [7] Ц.Амартүвшин, С.Болормаа, “Эдийн засгийн өсөлт ба тэгш бус байдал,” *Монголын хүн амын сэтгүүл*, б. 28, 2018.
- [8] Азийн Хөгжлийн Банк, “Хүртээмжтэй бөгөөд тогтвортой өсөлтийн үнэлгээ,” 2021.
- [9] Ч.Дэлгэржаргал, Ж.Арман, Б.Аръяасүрэн, “Хүртээмжтэй өсөлт,” *Мөнгө, санхүү, баялаг*, 2021.
- [10] Andrei Mikhnev, Ikuko Uochi, Lydia Kim, “COVID-19 цар тахлын дараах Монгол Улс: Хүртээмжтэй өсөлтөд тулгарч буй эрсдэлүүд,” *East Asia & Pacific on the Rise*, 2022.
- [11] “Тогтвортой хөгжлийн зорилго,” 2016. [Холбоос]: <https://sdg.1212.mn/Home/Index>